

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, ЗӨРЧИЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛААГАНЫ ЗАРДАЛ

АХЛАХ МӨРДӨГЧ,
ХОШУУЧ Ц.НЯМЖАРГАЛ

2019.04.05

Зардал гэдэг нь:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжыг хангах, гэмт хэрэг, зөрчлийг хуулийн хүрээнд хурдан шуурхай шалгахад шаардлагатай байгаа санхүүгийн дэмжлэгийг хэлнэ.

Эрхзүйн орчин:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4, 11.5, 11.6 дугаар зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”, ЦБҮАЖ /код-320/ болон бусад хууль тогтоомж, журамд зааж өгсөнөөр эрх зүйн орчин бүрдсэн.

- Зорилго:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөл байдлыг хангах зорилгоор мөрдөн шалгах ажиллагааны явцад үүссэн зардлыг төсөвт тусгах, гэм буруутай этгээдээс гаргуулахтай холбоотой баримт, материалыг бүрдүүлэн хавтаст хэрэгт тусгах ажиллагааны дэг горимыг тогтооход оршино.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах зардлаас бүрдэнэ.

- Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгчид төлөх зардал
- Эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, шинжлүүлэхэд гарах зардал
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарах зардал
- Гэрч, хохирогч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарах зардал
- Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон шууд зардал

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд дараахь зардал хамаарна:

1. Хохирогч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид төлөх зардал;
2. Эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, устгахад гарах зардал;
3. Тухайн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал;
4. Хохирол, хор уршгийн үнэлгээ, шинжилгээ хийлгэхтэй холбоотой зардал.

•

Хамрах хүрээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас дор дурдсан зардлыг төр хариуцах бөгөөд уг зардалтай холбоотой баримт, материалыг бүрдүүлэн хавтаст хэрэгт хавсаргаж, прокурорын яллах дүгнэлтийн хавсралтад тусгуулан шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй. Үүнд:

- а/ Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч,
- мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгчид төлөх зардал
- б/ Эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, шинжлүүлэхэд гарах зардал;
- в/ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргосон яллагдагч,
- шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарах зардал;
- г/ Гэрч, хохирогч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарах зардал;
- д/ Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал. / Бусад зардалд хэргийн газар, орон байр, хүний бие, цогцост үзлэг, нэгжлэг, шинжилгээ хийх, цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх, мөрдөн шалгах туршилт хийх, мэдүүлгийг газар дээр нь шалгах, таньж олуулах ажиллагаа явуулах, ялтныг хорих ангид очиж байцаах, дуудлагаар авахад гарсан болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсны үр дүнд үүссэн ажил гүйцэтгэсний хөлс, зардал багтана/

Зардлыг тодорхойлох

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”-д зааснаар тодорхойлно.

ЗАРДЛЫГ ГАРГУУЛАХААР НЭХЭМЖЛЭХ

- **Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч**
- **эрүүгийн хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалтай холбоотойгоор цагдаагийн байгууллагад үүссэн өр, авлагыг гэм буруутай этгээдээс гаргуулахад шаардагдах үндэслэл, нөхцлийг Иргэний хуулийн 229, 230 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 1.8 дугаар зүйл, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”, бусад хууль тогтоомжоор тодорхойлно.**

- **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад алба, нэгж, нутаг**
- **дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь цагдаагийн байгууллагад үүссэн өр, авлагыг гэм буруутай этгээдээс гаргуулахад шаардагдах**
- **дээрх зардлын холбогдох баримт сэлт, материалыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох маягт 1, 2”-ын хамт эрүүгийн хэрэгт нь хавсаргана.**

Цаг үеийн нөхцлөөс шалтгаалан баримтын бүрдүүлбэр бүрэн хангагдаагүй бол тодорхой ажиллагааны зардлыг хэсэгчлэн гаргах, прокурор болон шүүхийн шатанд гаргаж болно.

Эрүүгийн хэрэгт цагдаагийн байгууллага, алба хаагч дээрх зардлын баримт гаргаагүй, эсхүл гаргасан баримт сэлт, материалыг шүүх хэлэлцээгүй орхисон бол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй.

Тухайн цагдаагийн байгууллага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалтай холбоотойгоор цагдаагийн байгууллагад үүссэн өр, авлагыг гэм буруутай этгээдээс нэхэмжлүүлэхээр Иргэний хууль тогтоомжид заасны дагуу алба хаагчийг иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаар томилуулахаар шийдвэрийг гаргаж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалтай холбоотой төсөв захирдаггүй нэгжид энэ зүйлийн иргэний хариуцагчтай холбоотой асуудал хамаарахгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалтай холбоотойгоор цагдаагийн байгууллагад үүссэн өр, авлагыг гэм буруутай этгээдээс гаргуулахад шаардагдах баримт сэлт, материал гэдэгт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан санхүүгийн анхан шатны баримт, иргэд хоорондын болон цагдаагийн байгууллагын тухайн нэгжтэй байгуулсан бичгийн хэлцэл, баримт, гэрээ, томилолтын хуудас, тээвэр, байр, хоолны зардал, цалингийн баримт, дундаж хөлсний хэмжээ тогтоосон баримт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох маягтын дагуу бичсэн тэмдэглэл, хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн зүйл байна.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”-ын Хоёрдугаар зүйлд заасны дагуу тооцох бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар тооцно. Үүнд:

а/хэргийн газар, орон байр, хүний бие, цогцост үзлэг, нэгжлэг, шинжилгээ хийх, цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх, мөрдөн шалгах туршилт хийх, мэдүүлгийг газар дээр нь шалгах, таньж олуулах ажиллагаа явуулах, ялтныг хорих ангид очиж мэдүүлэг авах, дуудлагаар явахад гарсан болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсны үрдүнд үүссэн ажил гүйцэтгэсний хөлс, зардлыг гарсан шууд зардлын хэмжээгээр;

б/нас барсан хүний цогцост үзлэг хийсэн мөрдөгчид 15000 /арван таван мянга/ төгрөгийн нэмэгдлийг олгохоор;

в/шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд оролцсон мөрдөгчид 15000 /арван таван мянга/ төгрөгийн нэмэгдлийг олгохоор;

г/цогцос муудаж ялзарсан, өмхийрсөн, цогцсын эрхтний хэсгийг олж цуглуулсан, булш ухаж шинжилгээ хийсэн, нэг дор хоёр буюу түүнээс дээш цогцост үзлэг хийсэн зэрэг тохиолдолд уг ажиллагааг хийсэн мөрдөгчид 20000 /хорин мянга/ төгрөг олгохоор.

Тухайн хэргийг харьяалах нэгжийн дарга нар оролцсон тохиолдолд нэмэгдлийг дарга нарт олгож болно.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн өмнөх шатанд гарсан зардлыг мөрдөгч тооцож, Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох маягт 1”-ийн дагуу тэмдэглэл үйлдэн, шуурхай шийдвэрлүүлэх ба холбогдох баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцохдоо эрх бүхий албан тушаалтны үйлдсэн тэмдэглэл /Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох маягт 2/-ийг үндэслэнэ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зардлыг мөрдөгч тухай бүр тэмдэглэл үйлдэн баталгаажуулна. Оролцогчоос бичгээр гаргасан нэхэмжлэлийг харгалзаж болно.

Мөрдөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын маягтыг бөглөн нэгжийн ахлах нягтлан бодогч, дарга болон дээд шатны даргаар баталгаажуулан харьяа алба нь нягталж, цагдаагийн төв байгууллагын санхүү хариуцсан нэгжид шилжүүлж шийдвэрлүүлнэ.

ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, НЭХЭМЖЛЭЛИЙН БҮРТГЭЛ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын төсвийг жилийн төсвийн төсөлд тусгаж, Санхүү, аж ахуйн албанд хүргүүлнэ.

Санхүү, аж ахуйн алба нь ирүүлсэн зардлын төсвийг нэгтгэн, Төсвийн тухай хуульд заасан цаг хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”-ын 1.2-т заасны заасны дагуу төсөвт тусгуулан санхүүжүүлэхдээ нэг эрүүгийн хэрэгт ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалтай холбоотойгоор цагдаагийн байгууллагад үүссэн өр, авлагыг гэм буруутай этгээдээс гаргуулах нэхэмжлэлд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар хяналт тавьж ажиллана.

Санхүү, аж ахуй алба нь цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан зардлыг нэхэмжлэх талаар мэргэжлийн туслалцаа үзүүлж, бүртгэлээр хяналт тавьж ажиллана.

Тухайн хэргийн онцлог, хийгдэх ажлын далайцаас хамаарч шинжилгээний зардлыг тухайн цагдаагийн нэгж төлөх боломжгүй бол цагдаагийн төв байгууллагаас санхүүжүүлж шийдвэрлэнэ.

БУСАД

Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналтын шатанд тухайн хэргийн яллагдагч нь өөрийн гэм буруугаа ухамсарлаж гарсан зардлыг сайн дураараа төлсөн тохиолдолд энэ талаар баримт үйлдэж, хавтаст хэрэгт хавсаргана.

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**